

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ НИСЛЭГ-ТЕХНИКИЙН
ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА БОЛОН ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН
ХООРОНД БАЙГУУЛСАН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

2009.10.09

Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралт, Монгол Улсын "Иргэний нисэхийн тухай" хуулийн 29 дүгээр зүйл, 42 дугаар зүйлийн 42.5 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохицуулахаар нэг талаас Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Нислэг-Техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба (НТОЗШША), нөгөө талаас Тээврийн прокурор энэ харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулав.

Талууд мэдэгдэх нь:

1. НТОЗШША-ны үйл ажиллагааны үндсэн зорилт нь иргэний нисэхийн осол, зөрчлийг шинжлэн шалгах, осол, зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны зөвлөмж гарахад орших бөгөөд гэм бурууг хуваарилаж, хариуцлага хүлээлгэхэд чиглэхгүй болно.

2. Иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгахдаа агаарын тээврийн байгууллагуудын нислэгийн аюулгүй ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, аюулгүй байдлаар өрсөлдөх чадварыг дээшлүүлэх шаардлагыг гол үндэс болгосон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хамтын ажиллагаа байна.

3. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагаанаас олж авсан мэдлэг, туршлага дээр үндэслэн талууд ослын үед хамтран ажиллах системийг бий болгон тогтоож осол гарсан тохиолдолд өөрсдийн мэдлэг, тоног төхөөрөмжийн мэдээллийн эх үүсвэрүүдийг үр дүнтэйгээр ашиглахад дэмжлэг үзүүлснээр иргэний нисэхийн аюулгүй ажиллагаанд хувь нэмрээ оруулна.

Нэг. ЗОРИЛГО

1.1 Энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийн зорилго нь ослыг шинжлэн шалгах чиглэлээр талууын хоорондын зүй зохистой хамтын ажиллагаанд зайлшгүй шаардлагатай асуудлыг тусгахад оршино.

Хоёр. ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү харилцан ойлголцлын санамж бичигт дараах тодорхойлолтын илэрхийллийг хэрэглэсэн болно.

- 2.1. Осол гэж Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтад тодорхойлсноор илэрхийлэгдэнэ.
- 2.2. Ноцтой зөрчил гэж осолд хүргэх дөхсөн аливаа зөрчил (Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын нэмэлт "С" болон ICAO-гийн дос 9156) буюу "ослын нөхцөл байдалд хүргэж болзошгүй зөрчлийг" гэж заасан тодорхойлолтоор ойлгоно.
- 2.3. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах гэдэг нь "Иргэний нисэхийн тухай МУ-ын хуулийн 3.1.21"-д зааснаар гарч болзошгүй нислэг-техникийн осол зөрчлөөс

урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүгнэлт хийх, түүнчлэн гарсан осол зөрчлийн шалтгааныг тогтоон аюулгүй ажиллагааны зөвлөмж бэлтгэх үйл ажиллагаа.

- 2.4. Шинжлэн шалгах баг гэдэг урьдчилан зохион байгуулагдаж, техник хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хангалт хийгдэж, сургалт дадлаганд хамрагдсан шинжлэн шалгагчид, шинжээчдээс бүрдсэн багийг,
- 2.5. "Бодит байдал" гэж нисэхийн ослын үйл явдлын өрнөл, гарсан нөхцөл, алга болсон байдал нотолгоог нэгтгэснийг ойлгоно.

Гурав. ХАМТЫН АЖИЛЛАГАА

Талууд дараах асуудал бүрээр хамтран ажиллана.

- 3.1. Мэдээлэл солилцох
- 3.2. Ослын газарт хяналт тогтоох
- 3.3. Нотлох баримт олж авах
- 3.4. Эмнэлгийн задлан шинжилгээ хийх
- 3.5. Сургалт, дадлагад хамтарсан байдлаар сургах

Дөрөв. НИСЭХИЙН ОСЛЫГ ШИНЖЛЭН ШАЛГАХ ЗАРЧИМ

- 4.1. Иргэний агаарын хөлгийн ослыг шалгахдаа шинжлэн шалгагч, прокурорын хяналт тогтоох үйл ажиллагааны чиг үүрэг, зарчим, байгууллага тус бүрийн хүлээх үүрэг, хариуцлага, гаргах шийдвэр хараат бус бие даасан байдал хуульчлагдсан гэдэгт санал нийлнэ.
- 4.2. НТОЗШША-ны шинжлэн шалгагчид ослын үндсэн шалтгаан техник, технологи, зохион байгуулалт, удирдлагын бичиг баримт, оролцогчдын үйл ажиллагаатай холбоотой шалтгааныг илрүүлэн тогтоож урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргахдаа хууль хяналтын байгууллагаас хараат бус бие даасан байна.
- 4.3. Прокурорын байгууллага мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа осол хаана хэрхэн болсон, мэдээлэл, баримт, нотолгооны материал цуглуулах, дүн шинжилгээ хийх, буруутанг олж тогтоох ажлыг Монгол Улсын хуульд заасан үндэслэл, журмыг баримтлан явуулна.
- 4.4. Талууд өөрсдийн зохион байгуулсан шинжлэн шалгах сургалт, дадлаганд нөгөө талынхаа шинжээчдийг урьж оролцуулж болно.

Тав. МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

- 5.1. Агаарын хөлгийн ослыг шалгах үед олж авсан нислэгийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэгдсэн мэдээллийг талууд солилцоно.
- 5.2. Мэдээллийг нийтэд нээлттэй болгох хүртэл талууд харилцан солилцсон мэдээллийн нууцыг хадгална.

Зургаа. НИСЭХИЙН ОСЛЫН ГАЗАРТ ХИЙХ ХЯНАЛТ

- 6.1. НТОЗШША-ны шинжээчид нисэхийн ослын газарт хориотой бүс тогтоох ба энэ асуудлаар прокурортой урьдчилан тохиролцоно.